

ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИД ХИЙГДСЭН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

/2014 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар/

№	Компанийн нэр	Хугацаа	Албан шаардлага хүргүүлсэн эсэх	Илэрсэн зөрчлийн тоо	Авсан албадлагын арга хэмжээ	Тайлбар
1	“Моннис даатгал” ХХК	2014.02.17-03.03	Үгүй	13	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг барагдуулж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Хороонд мэдэгдэх хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Даатгалын тухай хуулийн 55.1 дэх заалтыг зөрчсөн тул Даатгалын тухай хуулийн 83.1.23-т заасны дагуу 1,0 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.	
2	“Ган зам даатгал” ХХК	2014.04.21-04.30	Үгүй	11	Даатгалын тухай хуулийн 9.1.6, Иргэний хуулийн 433.1, 438.1, Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.1, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дэх заалтыг тус тус зөрчсөн тул Даатгалын тухай хуулийн 83.1.32 дахь заалтыг үндэслэн даатгагчийг 500,000.0 /таван зуун мянган төгрөг/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.	
3	“Мандал генерал даатгал” ХХК	2014.05.20-06.06	2014.08.20-79	22	Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.6, Хорооны 2012 оны 356 дугаар тогтоолын 3.1, 3.4, Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.9, 3.1.11, Даатгалын тухай хуулийн 56.1, Даатгалын тухай	

					<p>хуулийн 21.3.1, НББ-ийн тухай хууль, Даатгалын тухай хуулийн 29.2-ыг тус тус зөрчсөн тул Даатгалын тухай хуулийн 83.1.3, 83.1.10, 83.1.32 дахь заалтыг үндэслэн даатгагчийг 3,100,000.0 /гурван сая нэг зуун мянган төгрөг/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.</p> <p>Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн тул тус хуулийн 6.1.2-т заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 9,600,000.0 /есөн сая зургаан зуун мянга/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.</p> <p>Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.5-ыг зөрчсөн тул тус хуулийн 28.1.6-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 960,000.0 /есөн зуун жаран мянга/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.</p>	
4	“Номин даатгал” ХХК	2014.06.17-07.04	2014.08.20-77, 2014.08.20-78	26	<p>Даатгалын тухай хуулийн 6, Хорооны 2012 оны 356 дугаар тогтоолоор батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг шинэчлэн батлах тухай тогтоолын 4, Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.6, Даатгалын тухай хуулийн 29.1, 30.1, Даатгалын тухай хуулийн 56.1-ийг тус тус зөрчсөн тул Даатгалын тухай хуулийн 83.1.10, 83.1.32 дахь заалтыг үндэслэн даатгагчийг 2,000,000.0</p>	

					<p>/хоёр сая төгрөг/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.5-ыг зөрчсөн тул тус хуулийн 28.1.6-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 960,000.0 /есөн зуун жаран мянга/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.</p>	
5	“Тэнгэр даатгал” ХХК	2014.09.22-10.10	Үгүй	25	<p>Даатгалын тухай хуулийн 55.1, Даатгалын тухай хуулийн 6, 14.2, Даатгалын тухай хуулийн 13.1.1, 13.1.2, 20.1, 67.1.1-ийг тус тус зөрчсөн тул Даатгалын тухай хуулийн 83.1.1, 83.1.23, 83.1.32 дахь заалтыг үндэслэн даатгагчийг 2,500,000.0 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.</p> <p>Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн тул тус хуулийн 6.1.2-т заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 9,600,000.0 /есөн сая зургаан зуун мянга/ төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.</p> <p>Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.5-ыг зөрчсөн тул тус хуулийн 28.1.6, даатгалын нөхөн төлбөрийг хохирогчид бус даатгуулагчид олгож байгаа нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 19.2, 19.3-ыг зөрчсөн тул 28.1.6-д заасныг тус тус үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 1 920 000.0 /нэг сая есөн зуун хорин мянга/ төгрөгөөр торгох арга</p>	

					ХЭМЖЭЭГ авсан.	
6	“Практикал даатгал” ХХК	2014.10.20-11.10			Шалгалт хийгдэж байна.	